

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Дарханы дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2024/03/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2024 он	Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас:70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас:70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитор: О.Мягмарсүрэн Утас: 70378845 Цахим хаяг: myagmarsureno@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.15 № 143
танай _____ -ны № _____ -т

“ДАРХАН ДУЛААНЫ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.БАТЖАРГАЛ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дарханы дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Дарханы дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус компанид Дархан-Уул аймгийн Засаг даргын 2023 оны 01-А/04 тоот захирамжаар нийтийн орон сууц барих зориулалтаар 800 кв газрыг 2 жилийн хугацаатай эзэмшүүлснээр Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 06 дугаар хурлын тэмдэглэлийн дагуу “Ноёдын туурь” ХХК-д орон сууцны барилгын зураг төсөл боловсруулах 50,000.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны бус орлогоос санхүүжүүлж, зураг төслийг биет бус хөрөнгөөр бүртгэж, тайлагнасан байна.

Аудитын гол асуудал

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 22 дугаар тогтоолоор ажиллагсдын үндсэн болон тарифт цалингийн хэмжээг шинэчлэн тогтоож, 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс олгож эхэлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Компанийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 20 зорилтын хүрээнд 166 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 6 ажил үргэлжлэн хэрэгжих шатандаа, 1 ажлын тодотгоолоор хасаж, гүйцэтгэлийг 95.8 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

009020256

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	344,453,526.05	572,843,066.96
1.1.2	Дансны авлага	530,843,989.10	603,450,418.55
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	16,197,628.34	-
1.1.4	Бусад авлага	15,649,227.09	130,088,788.15
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	520,852,344.64	624,698,871.96
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	30,448,393.74	33,469,471.92
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,458,445,108.96	1,964,550,617.54
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	24,717,714,286.05	23,859,539,981.91
1.2.2	Биет бус хөрөнгө	895,598,551.90	1,026,811,128.72
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	25,613,312,837.95	24,886,351,110.63
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	27,071,757,946.91	26,850,901,728.17
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	191,797,313.50	165,730,242.60
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	-	75,044,977.82
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	10,223,775.54
2.1.1.5	Богино хугацаат зээл	342,940,000.00	449,000,000.00
2.1.1.6	Хүүний өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	132,248,361.15	111,731,553.75
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	666,985,674.65	811,730,549.71
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	666,985,674.65	811,730,549.71
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	17,920,722,852.44	17,920,722,852.44
2.3.2	Өмч: - хувийн	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,915,919,985.26	2,915,919,985.26
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	2,802,982,550.80	2,811,702,550.80
2.3.9	Хуримтлагдсан ашиг	2,765,146,883.76	2,390,825,789.96
2.3.11	Эздийн өмчийн дүн	26,404,772,272.26	26,039,171,178.46
2.4	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	27,071,757,946.91	26,850,901,728.17

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
01	Борлуулалтын орлого (цэвэр)	11,049,218,514.30	13,256,395,365.16
02	Борлуулалтын өртөг	7,148,836,076.72	7,389,980,443.70
03	Нийт ашиг (алдагдал)	3,900,382,437.58	5,866,414,921.46
04	Түрээсийн орлого	1,620,000.00	1,944,000.00
05	Хүүний орлого	-	173,439.13
06	Ногдол ашгийн орлого	-	-
07	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
08	Бусад орлого	588,137,789.73	1,479,159,331.21
09	Борлуулалт, маркетингийн зардал	1,929,493,392.00	3,007,461,498.76
10	Ерөнхий ба удирдлагын зардал	3,241,607,012.27	3,799,339,740.65
11	Санхүүгийн зардал	20,182,755.11	76,278,024.32
12	Бусад зардал	247,094,196.55	570,330,494.94
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	91,146,131.57	268,585,683.02
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(1,039,383,260.19)	(374,303,749.89)
19	Орлогын татварын зардал	-	17,343.91
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(1,039,383,260.19)	(374,321,093.80)
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(1,039,383,260.19)	(374,321,093.80)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	-	-
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	17,920,722,852.44	-	2,915,919,985.26	2,802,982,550.80	2,765,146,883.76	26,404,772,272.26
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	17,920,722,852.44	-	2,915,919,985.26	2,802,982,550.80	2,765,146,883.76	26,404,772,272.26
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өөрчлөлт	-	-	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	-
Ногдол ашиг	-	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн	-	-	-	-	-	-
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,920,722,852.44	-	2,915,919,985.26	2,802,982,550.80	2,765,146,883.76	26,404,772,272.26
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өөрчлөлт	-	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	17,920,722,852.44	-	2,915,919,985.26	2,802,982,550.80	2,765,146,883.76	26,404,772,272.26
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	-
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	8,720,000.00	-	8,720,000.00
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	(374,321,093.80)	(374,321,093.80)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн	-	-	-	-	-	-
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,920,722,852.44	-	2,915,919,985.26	2,811,702,550.80	2,390,825,789.96	26,039,171,178.46

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	12,303,661,030.51	15,705,395,670.50
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	11,682,462,705.34	14,809,882,175.01
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
	Буцаан авсан албан татвар	-	17,066.47
	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
	Бусад мөнгөн орлого	621,198,325.17	895,496,429.02
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	11,719,277,206.19	15,103,959,292.74
	Ажиллагчдад төлсөн	3,179,629,001.37	4,250,974,454.81
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,087,500,000.00	1,477,452,401.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	4,527,640,621.81	5,535,237,056.68
	Ашиглалтын зардалд төлсөн	384,233,213.95	552,426,126.75
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	143,912,102.54	138,539,691.40
	Хүүний төлбөрт төлсөн	20,182,755.11	76,278,024.32
	Татварын байгууллагад төлсөн	961,448,714.44	1,266,071,189.76
	Даатгалын төлбөрт төлсөн	10,955,887.00	10,358,021.00
	Бусад мөнгөн зарлага	1,403,774,909.97	1,796,622,327.02
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	584,383,824.32	601,436,377.76
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	173,439.13
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
	Хүлээн авсан хүүний орлого	-	173,439.13
	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
	Бусад	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	690,014,055.00	479,280,275.98
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	690,014,055.00	390,370,675.98
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	88,909,600.00
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
	Бусдад олгосон зээл болон урьдчилга	-	-
	Бусад	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(690,014,055.00)	(479,106,836.85)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,139,471,164.21	2,554,192,543.06
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,139,471,164.21	2,554,192,543.06

	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
	Төрөл бүрийн хандив	-	-
	Бусад	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	796,531,164.21	2,448,132,543.06
	Зээл,өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	796,531,164.21	2,448,132,543.06
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
	Төлсөн ногдол ашиг	-	-
	Бусад	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	342,940,000.00	106,060,000.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	237,309,769.32	228,389,540.91
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	107,143,756.73	344,453,526.05
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	344,453,526.05	572,843,066.96

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт		Хэмжих нэгж	2022 оны гүйцэтгэл	2023 оны			
					Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Худалдаж авсан дулаан		мян.Гкал	601.3	622.9	647.4	24.5	104.0
	Үүнээс:	Уураар	мян.Гкал	14.3	12.0	15.5	3.5	129.0
		Усаар	мян.Гкал	587.0	610.9	631.9	21.0	103.0
	Худалдаж авсан ДЭХ-ний өртөг		мян.төг	4,431,649.0	4,950,000.0	4,050,082.4	(899,917.6)	82.0
	ДЭХ-ний алдагдал	хувиар	хувь	0.2	0.2	0.2	-	100.0
		биетээр	мян.Гкал	90.1	93.8	96.6	2.9	103.0
Борлуулах дулааны эрчим хүч		мян.Гкал	511.2	529.2	550.8	21.7	104.0	
2	Нийт орлого		мян.төг	11,638,975.8	13,652,000.6	14,737,672.1	1,085,671.5	108.0
	Үүнээс:	Борлуулалтын орлого	мян.төг	11,049,218.0	13,252,000.6	13,256,395.4	4,394.8	100.0
		Үйл ажиллагааны бус орлого	мян.төг	589,757.8	400,000.0	1,481,276.8	1,081,276.8	270.0
Борлуулалтын орлого цуглуулалт		мян.төг	12,180,690.6	13,252,000.6	13,222,391.3	(29,609.3)	100.0	
3	Нийт зардал		мян.төг	12,678,359.6	15,692,103.3	15,111,975.9	(580,127.4)	96.0
	Үүнээс:	Үйл ажиллагааны зардал	мян.төг	7,945,967.4	10,616,160.8	10,308,261.4	(307,899.4)	97.0
		Худалдаж авсан ДЭХ-ний өртөг	мян.төг	4,431,649.0	4,950,000.0	4,050,082.4	(899,917.6)	82.0
		Үйл ажиллагааны бус зардал	мян.төг	300,743.2	125,942.4	753,632.1	627,689.7	498.0
ҮХЭ-ийн зардал		мян.төг	1,764,745.7	1,933,637.3	1,796,761.2	(136,876.1)	93.0	
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/		мян.төг	(1,039,383.8)	(2,040,102.7)	(374,303.7)	1,665,799.0	18.0
5	Татварын дараах ашиг /алдагдал/		мян.төг	(1,039,383.8)	(2,040,102.7)	(374,321.1)	1,665,781.6	18.0
6	Борлуулалтын орлогын 1 төг-т ногдох зардал		мян.төг	1.089	1.149	1.025	(0.1)	89.0
7	Нийт авлага		мян.төг	562,690.8	818,307.2	733,539.2	(84,768.0)	90.0
	Үүнээс:	Борлуулалтын авлага	мян.төг	555,271.8	861,375.0	592,677.3	(268,697.7)	69.0
		Бусад	мян.төг	7,419.0	(43,067.8)	140,861.9	183,929.7	(227).0
8	Нийт өглөг		мян.төг	666,985.7	1,025,560.5	798,580.5	(226,980.0)	78.0
	Үүнээс:	УХӨТ	мян.төг	-	-	-	-	-
		БХӨТ	мян.төг	666,985.7	1,025,560.5	140,861.9	(226,980.0)	78.0
9	Нийт ажиллагсад		тоо	184	191	191	-	100.0
10	Цалингийн сан		мян.төг	3,762,856.4	5,267,152.3	5,286,140.3	18,988.0	100.0
11	Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт		мян.төг	1,196,210.0	1,176,230.0	1,054,090.0	(122,140.0)	90.0
	Үүнээс:	Их засвар	мян.төг	876,010.0	852,500.0	734,540.0	(117,960.0)	86.0
		ТЗБАХ	мян.төг	181,720.0	124,460.0	125,120.0	660.0	101.0
Хөрөнгө оруулалт		мян.төг	138,480.0	199,270.0	194,430.0	(4,840.0)	98.0	

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 13,150.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Программд нэмэлт хөгжүүлэлт хийх 91/2023 тоот гэрээний үлдэгдэл төлбөрийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй нь НББОУС 37 *“Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө”* болон *“Толилуулга”* батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн байдлын тайлангийн богино хугацаат өр төлбөр дансанд бүртгэж залруулав.

Мөн аудитаар нийт 116,661.9 мянган төгрөгийн зөрчил² илэрсэн тул 4,813.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 101,465.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 10,383.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг хүргүүлээ.

3.1 Төлбөрийн акт

ТУЗ-ийн 2021 оны 18 дугаар тогтоолоор баталсан *“Ажилтнуудад жилийн үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгох журам”*-д заагаагүй ажил, албан тушаал эрхэлж байгаа 4 албан хаагчид 4,813.9 мянган төгрөгийн нэмэгдэл хөлсийг илүү тооцож олгосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.12-т *“Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн албан хаагч эрх бүхий байгууллагаас тогтоосон цалин хөлснөөс бусад төрлийн шан харамж, урамшуулал авахыг хориглоно”*, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т *“Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”*, 15.1.3-т *“хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д *“Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”* гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн *“нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангаагүй тул төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

Тайлант оны бизнес төлөвлөгөөнд тусгагдсан эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгийн 30,806.0 мянга, албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих, нөхөн сэргээх хөтөлбөрийн 20,780.0 мянга, орон сууцны барилгын зураг төслийн 50,000.0 мянга, нийт 101,465.0 мянган төгрөгийн худалдан авалтыг ТБОНӨХБАҮХАТХ-д заасан журмыг хэрэглээгүй, цахим системээр зохион байгуулж, үр дүнг мэдээлээгүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5-д *“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана”*, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т *“Захиалагч энэ хуулийн 8.1.2-т заасан босго үнээс бага төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг энэ хуулийн 7.1 дэх хэсэгт заасан журмыг мөрдөхгүйгээр шууд худалдан авч болно”*, 8 дугаар зүйлийн 8.1-т *“Засгийн газар нь барааны, ажлын, үйлчилгээний гэсэн ангилал тус бүрээр дараахь босго үнийг тогтооно”*, 33 дугаар зүйлийн 33.1-т *“Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно”* гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн *“нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангаагүй тул зөрчлийг арилгах, цаашид гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өглөг данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

- Тайлант оны сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан мэргэшсэн инженер бэлтгэх, ХАБЭА-н сургалтыг зохион байгуулаагүйгээс үүссэн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдээдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

- Цаашид уг алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ажиллах

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5³-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 09 дүгээр сарын 30-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

³ Шалгаагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Програмд нэмэлт хөгжүүлэлт хийх 91/2023 тоот гэрээний үлдэгдэл төлбөрийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй	1	13,150.0	1	13,150.0	-	-	1	13,150.0	-	-	-	-
Дүн	1	13,150.0	1	13,150.0	-	-	1	13,150.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалт-ны тоо	Тоо	Дүн
Хууль тогтоомжид заагаагүй нэмэгдэл хөлсийг илүү тооцож олгосон.	1	4,813.9	1	4,813.9	-	-	-	-	-	-	-	-
Тайлант оны сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан мэргэшсэн инженер, ХАБЭА-н сургалтуудыг зохион байгуулаагүйгээс үүссэн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	1	10,383.0	-	-	-	-	1	10,383.0	-	-	-	-
Витамины багцийн 20.7 сая, барилгын зураг төслийн 50.0 сая, эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгийн 30.7 сая, нийт 101.4 сая төгрөгийн худалдан авалтыг ТБОНӨХБАҮХАТХ-д заасан журмыг хэрэглээгүй, цахим системээр зарлаагүй.	1	101,465.0	-	-	1	101,465.0	-	-	-	-	-	-
Дүн	3	116,661.9	1	4,813.9	1	101,465.0	1	10,383.0	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	1	-	-	-
2	Төсөл, хөтөлбөр	-	-	-	-	-	-	-	-
3	ЗГТС	-	-	-	-	-	-	-	-
4	ТТЗ	-	-	-	-	-	-	-	-
5	ТЕЗ	-	-	-	-	-	-	-	-
	НИЙТ	1	1	-	-	1	-	-	-